

**ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН
ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН
ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 06 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд газрын тосны бүтээгдэхүүний импортын хараат байдлыг бууруулах, дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах зорилтын хүрээнд газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдээр хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын эрх зүйн тодорхойгүй байдлыг арилгах, өмнө байгуулсан гэрээний нөхцөлийг хамгаалах, үүссэн татвар, шимтгэлийн маргааныг шийдвэрлэх, нөөц ашигласны төлбөр, татвар, шимтгэлийг тухайн бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцөлийн дагуу шийдвэрлэх эрх зүйн үндсийг бий болгох, хөрөнгө оруулагчдын эрх зүйн эрсдэлийг бууруулж, хайгуул, олборлолтыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, шинэ орд газар илрүүлэх, баталгаат нөөцийг өсгөх зэрэг эрх зүйн болон хөрөнгө оруулалтын ач холбогдолтой хэмээн үзэж Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, уг хуулийн төслийг дагалдуулан Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг боловсруулан яаралтай дэгээр хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлжээ.

Хууль санаачлагч нь хуулийн төсөл батлагдсанаар бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх зүйн тогтвортой байдал хангагдах, газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын орчин сайжрах, хайгуул, олборлолтын үйл ажиллагаа эрчимжих, төр болон хөрөнгө оруулагч хоорондын маргаан буурах, газрын тосны олборлолт тасалдах эрсдэл буурч, боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдээр хангах нөхцөл сайжрах зэрэг эерэг үр дүн бий болно гэж үзжээ.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байна.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд газрын тосны Тосон-Уул XIX талбай яагаад газрын тосны нөөц ашигласны төлбөрт хамрагдахгүй байгаа, ялгаатай зохицуулалт хийх болсон хууль эрх зүйн болон гэрээний үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Засгийн газар болон хөрөнгө оруулагчдын хооронд үүссэн их хэмжээний татвар, шимтгэлийн маргаан, улсын эдийн засаг болон төсөвт ямар нөлөө үзүүлэх, Засгийн газар, эрх ашгаа хангалттай хамгаалж ажилласан эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Түүнчлэн Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд өмнө нь байгуулсан гэрээний алдаа дутагдлаа дүгнэн хойшид шинэ гэрээ байгуулахдаа алдаа, сургамжаа давтахгүй байх талаар санал хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалт явуулахад Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 60.9 хувь, Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг 60.9 хувь, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 60.9 хувь, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг 65.2 хувь, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 65.2 хувь, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг 65.2 хувийн саналаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

